



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

2021.05.05 № 1405
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцохоор нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн эсэхийг хяналаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль тогтоомж холбогдох бусад баримтыг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч Дангаасүрэнгийн Энхбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 33.4 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр /.....⁷..... хуудас/-ийг хавсаргав.

Хүндэтгэсэн,




Д.ЗАНДАНБАТ


**Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2021 оны ээлжит сонгуульд оролцох**

**Хөдөлмөрийн үндэсний нам,
Монголын социал демократ нам,
Зүй ёс намын**

**“ЗӨВ ХҮН ЭЛЕКТОРАТ”
эвслээс нэр дэвшигчийн
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**ХӨДӨЛМӨРИЙН
ҮНДЭСНИЙ НАМ**



**МОНГОЛЫН СОЦИАЛ
ДЕМОКРАТ НАМ**



ЗҮЙ ЁС НАМ



**“ЗӨВ ХҮН ЭЛЕКТОРАТ” эвслээс
Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч**

/Дангаасүрэнгийн Энхбат/ -2

Улаанбаатар хот
2021 он

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний нам, Монголын социал демократ нам, Зүй ёс намын “ЗӨВ ХҮН ЭЛЕКТОРАТ” эвслээс нэр дэвшигч Дангаасүрэнгийн Энхбатын мөрийн хөтөлбөр нь Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулсан баримт бичиг болно.

Уриа: Иргэдээ дээдэлж, эвийг сахиулан дэлхийн Монголыг бүтээх үйлсэд манлайлна.

Мөрийн хөтөлбөрийн агуулга:

НЭГ.	МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ЭВ НЭГДЭЛ, ШУДАРГА ЁС, ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ХОЁР.	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТУСГААР ТОГТНОЛОО ХАМГААЛАГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ГУРАВ.	БОЛОВСРОНГУЙ ТОГТОЛЦОО, ТЭРГҮҮНИЙ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫГ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ДӨРӨВ.	ПАРЛАМЕНТЫН АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭГЧ, ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ТАВ.	БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ТУУШТАЙ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ЗУРГАА.	ИННОВАЦЫГ ДЭМЖДЭГ, ЧӨЛӨӨТ, ЭРҮҮЛ, ӨРСӨЛДӨХ ЧАДВАР БҮХИЙ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ДОЛОО.	УЛС ОРНЫ ЭРХ АШГИЙГ ДЭЭДЭЛЖ, ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦСЭН, ЭРХ ТЭГШ ГАДААД ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
НАЙМ.	ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ, МОНГОЛЫН ИРЭЭДҮЙГ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА
ЕС.	ИРГЭДЭЭ ТҮШСЭН, АЛЬ НЭГ БҮЛГИЙН БИШ НИЙТ МОНГОЛЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА


070000003
0019120308
* * * * *

НЭГ. МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ЭВ НЭГДЭЛ, ШУДАРГА ЁС, ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.

- 1.1. Монголын ард түмний эв нэгдэл, язгуур ашиг сонирхлыг ямагт дээдэлж, нийгмийн бүлэг, улс төрийн хүчнүүдийн зөвшилцлийг дэмжиж ажиллана.
- 1.2. Ёс зүйтэй, хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй Монгол хүн, Монгол нийгмийг төлөвшүүлэхэд онцгой анхаарч, хүний биш хуулийн засаглалын дор хараат бус, алагчилж тал хардаггүй шударга шүүхийн зарчмыг хатуу сахиулж, шүүхийн шинэтгэлийг тууштай дэмжих бодлого баримтална.
- 1.3. Нийгмийн тэгш бус байдлыг бууруулахын тулд иргэд үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, албан тушаал болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахын эсрэг, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөдөлмөрлөх үндсэн эрхээ эдлэх тэгш бололцоог хангахын төлөө зүтгэнэ.
- 1.4. Ёс зүйн хариуцлагын тогтолцоог төрийн албаны бүх шатанд бүрдүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, цахим хэлбэрт оруулах, улс төрийн томилгоог халж өндөр боловсролтой, мэргэшсэн төрийн албан хаагчийг чадамжид суурилсан тогтолцоогоор дэвшүүлдэг болгохын төлөө улс төрийн намуудтай хамтран ажиллана.
- 1.5. Сайн засаглалыг бэхжүүлэх, төрийн бодлого, төрийн үйлчилгээг сайжруулахын тулд төрийн үйл ажиллагааг хянадаг иргэний нийгмийн эгэх хариуцлагын механизмыг хөгжүүлэхэд иргэд, олон нийтийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.
- 1.6. Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг судлан хөгжүүлэх, нандигнан өвлүүлэх, дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх үйлсэд онцгой анхаарч, дэлхийн монгол судлалыг хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.

ХОЁР. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТУСГААР ТОГТНОЛОО ХАМГААЛАГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 2.1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг сахин биелүүлж ажиллана.
- 2.2. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоог бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Авилгатай тэмцэх, авилгаас ангид ажиллаж, амьдрах ёс зүй, соёлыг хэвшүүлэх, нийгмийн соён гэгээрлийн ажлыг бүхий л талаар дэмжиж ажиллана.
- 2.4. Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг ханган баталгаажуулахыг дэмжин ажиллана.
- 2.5. Иргэн бүр үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах үйлсийг дэмжин ажиллана.
- 2.6. Батлан хамгаалах бодлогод түүхэн уламжлал, үндэсний болон газарзүйн онцлогийг дэлхий дахины хөгжил дэвшил, ололттой хослуулах зарчим баримтлана.
- 2.7. Батлан хамгаалах салбарын шинэчлэлийг эрчимжүүлэн, салбарын бодлогыг Монгол Улсын хөгжлийн стратегитай уялдуулж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн, мэргэжлийн хүний нөөц бүхий зэвсэгт хүчин бүрэлдүүлэхэд анхаарч, дэмжиж ажиллана.




ГУРАВ. БОЛОВСРОНГУЙ ТОГТОЛЦОО, ТЭРГҮҮНИЙ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫГ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 3.1 Гэр бүлийн суурь хүмүүжилд анхаарч, иргэн бүр бага балчраасаа эхлэн бусдыг, ахмадаа хүндэлдэг, өндөр ёс суртахуунтай, дүрэм журмыг чанд сахидаг, иргэний эрх, үүргээ ухамсарласан, харилцааны өндөр соёлтой, түүх соёлоо мэддэг, үндэсний бахархалтай, эх оронч өв тэгш иргэн хүн болж төлөвшихийг дэмжиж ажиллана.
- 3.2 Бага насны хүүхэд бүр цэцэрлэг, сургуульд хамрагдах, төлөвшин боловсрох тэгш боломжоор хангагдах болон сургууль цэцэрлэг, багш сурган хүмүүжүүлэгчийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжиж ажиллана.
- 3.3 Бага, дунд, дээд боловсролын байгууллагын сурган хүмүүжүүлэх чадавхыг дээшлүүлэх, оюутан сурагч бүр сурч боловсрох, бие бялдраа хөгжүүлэх таатай нөхцлөөр хангагддаг байхад анхаарч, сурган хүмүүжүүлэх байгууллагын стандартыг төгөлдөржүүлж, мөрдүүлэх, сургалтуудыг төрөлжүүлэх аливаа санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.4 Монгол хүн дэлхийд өрсөлдөх боловсрол, ур чадвартай, хөрвөх чадвартай байхыг чухалчилж, боловсрол, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний салбар дахь төрийн дэмжлэг, хэрэгжилт, үр дүнг сайтар хянадаг тогтолцоог бүрдүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 3.5 Боловсрол, шинжлэх ухааны салбарт техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, сурган хүмүүжүүлэх, мэдлэг олгох аливаа үйл ажиллагаа хүртээмж өндөртэй, өгөөж сайтай, тэгш боломжтой байхад онцгой анхаарч ажиллана.
- 3.6 Иргэдийнхээ орлогын ялгааг бууруулахын тулд боловсролын тэгш бус байдлыг арилгахад онцгой анхаарал хандуулж ажиллана.

ДӨРӨВ. ПАРЛАМЕНТЫН АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭГЧ, ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 4.1 Парламентын ардчилал бол Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн баталгаа хэмээн үзэж, Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалтыг төгөлдөржүүлэх, Ерөнхийлөгчийн бүрэн эрхээс шаардлагагүй бүрэн эрхүүдийг төрийн зохих байгууллагуудад шилжүүлэх шинэтгэлийг санаачлан ажиллана.
- 4.2 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын эрх үүрэг, эрхлэх асуудалд хутгалдан оролцдог буруу жишгээс зайлсхийж, Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заагдсан бүрэн эрхэд хамааралгүй чиг үүргүүдийг ердийн хуулиар олгосныг өөрчлөх чиглэлээр хууль тогтоох үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 4.3 Сонгуулийн хууль тогтоомжийг өөрчлөн шинэчилж, хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоог хуульчлах замаар улс төрийн намуудын төлөвшилтийг түргэсгэх, гарааны ижил төвшинд, шударгаар, бодлогоор өрсөлдөх эрх зүйн орчинг бүрдүүлэхийг дэмжинэ.
- 4.4 Улс төрийн намын тухай хуулийг өөрчлөн шинэчилж, улс төрийн намууд бизнес бүлэглэлүүд болон мөнгөнөөс хараат бусаар оршин тогтнож, хөгжих, төлөвших боломж бүхий эрх зүйн орчинг бүрдүүлэхийг дэмжинэ.
- 4.5 Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох, бие даасан байдлыг хангах чиглэлийн шинэтгэлийн бодлогыг дэмжин ажиллана.
- 4.6 Авилгалтай тэмцэх газрын хараат бус, бие даасан байдлыг хангах улс төр, эрх зүйн орчинг бүрдүүлэхийг дэмжинэ.
- 4.7 Ард түмний итгэлийг олсон шүүхийн тогтолцоо болон шударга ёсыг бэхжүүлэх, авилгыг устгах чиглэлээр боловсрол, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг дэмжинэ.



ТАВ. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ТУУШТАЙ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 5.1 Ой мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн тогтвортой байдлыг хадгалахад онцгой анхаарал хандуулна.
- 5.2 Цэвэр усны хязгаарлагдмал нөөцийн хэрэглээг илүү оновчтой байлгах, ус цэвэршүүлэх, хаягдал ус дахин боловсруулах, усны бохирдлыг бууруулах техник технологийг нэвтрүүлэх, усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах зэрэг арга хэмжээнүүдийг дэмжиж ажиллана.
- 5.3 Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлэх, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх, хохирол багатай даван туулах боловсронгуй тогтолцоог бүрдүүлж ажиллахыг дэмжинэ.
- 5.4 Уул уурхайн хайгуул, олборлолт, нөхөн сэргээлт, тээвэр зэргийг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй зохион байгуулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлогыг дэмжинэ.
- 5.5 Хот суурин газрын агаар, хөрсний бохирдол, хог хаягдал, ногоон байгууламжийн асуудалд анхаарал хандуулж, хот суурины ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг дахин боловсруулах, хот суурин газруудын дулааны алдагдал болон агаарын бохирдлыг бууруулах санал, санаачилгыг дэмжинэ.
- 5.6 Хүлэмжийн хий бууруулах, байгаль хамгаалах, агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилга, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжих, санхүүжилт, хөрөнгө оруулалт татах зориулалттай төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.

ЗУРГАА. ИННОВАЦИД СУУРИЛСАН, ЧӨЛӨӨТ, ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН БҮХИЙ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ ДЭМЖИГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 6.1 Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, ажил эрхлэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, ЖДҮ, орон нутгийн хөгжил, орлого хуваарилалт, хүртээмжийн тэгш бус байдлуудыг бууруулах бодлогыг дэмжиж ажиллана.
- 6.2 Гадаад өрийн асуудлыг богино болон дунд хугацаанд шийдэх талаар гадаад улсууд, олон улсын эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, уул уурхайн салбарын бодлогыг эдийн засгийн аюулгүй байдлын асуудлыг шийдэх гол салбарын бодлогын төвшинд авч үзэж, олон жил дамжсан улс төрийн популизм, авилгыг бууруулах бодлогыг дэмжиж ажиллана.
- 6.3 Шинэ технологийг шуурхай нэвтрүүлэх буюу блокчэйн, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын технологийн шийдлүүд, нанотехнологи, биотехнологи, хөдөө аж ахуй, эрчим хүч, химийн болон бусад салбарт технологийн дэвшлийг төр, бизнесийн бүх төвшний хэрэглээнд хурдтай бөгөөд бусдаас өрсөн шийдэмгий нэвтрүүлэх, өрсөлдөөний давуу талыг олж, үр шимийг нь түрүүлж хүртэх бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
- 6.4 Монгол орны эдийн засгийн харьцангуй давуу тал дээр үндэслэн өрсөлдөх чадвар бүхий уул уурхай, МАА, газар тариалан, МАА-н бүтээгдэхүүнд суурилсан боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 6.5 Эдийн засгаа тэтгэх банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн хүчирхэг тогтолцоог хөгжүүлж, финтекийн салбарыг бэхжүүлж, бүс нутагтаа өрсөлдөхүйц хэмжээний үндэсний корпорацуудыг тэтгэн хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 6.6 Монголын уламжлалт нүүдлийн ахуйд цахим технологи, эрчим хүчний эх үүсвэр, цэвэр усан хангамж, түүхий эд боловсруулах бичил үйлдвэрлэл гэх мэт орчин үеийн технологийн ололтыг

- нэвтрүүлэх, малчдын эрүүл, тохитой орчинд амьдрах, хөгжих, аж ахуй эрхлэх боломжийг сайжруулах, энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалт татах татварын бодлогыг дэмжинэ.
- 6.7 Эдийн засаг, бизнест дарамт учруулахгүй, энгийн ойлгомжтой, үр нөлөө бүхий, шударга татварын тогтолцоо, бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин, шударга өрсөлдөөнийг бий болгохыг дэмжинэ.

ДОЛОО. УЛС ОРНЫ ЭРХ АШГИЙГ ДЭЭДЭЛЖ, ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦСЭН, ЭРХ ТЭГШ ГАДААД ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 7.1 Монгол Улсын Тусгаар тогтнол, Бүрэн эрхт байдал, Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарч, хөрш хоёр оронтой найрсаг харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- 7.2 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан тулгуур бодлогууд болон “Туравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд томоохон төслүүдийг хамтран хэрэгжүүлэхэд чиглэсэн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 7.3 Бүс нутгийн болон олон улсын байгууллагууд, дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Монгол Улсын байр суурь, жин нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн алхмуудыг авч хэрэгжүүлнэ. Олон улсын дээд хэмжээний уулзалтууд, хурал, бусад хамтарсан арга хэмжээг хүлээн авч зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, улмаар Монгол Улсыг олон улсын яриа хэлэлцээний төв, зангилаа болгоход чиглэсэн алхмуудыг хэрэгжүүлнэ.
- 7.4 Гадаад харилцаа эрхэлсэн төрийн төв байгууллагын болон төрийн бусад байгууллагын гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн албан хаагчдын боловсрол, мэдлэг, ур чадварт онцгойлон анхаарч, энэ чиглэлд мэргэшсэн байх шаардлага тавина.
- 7.5 Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортын хэт хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон, байгалийн баялаг, нөөцөд тавих хяналт алдагдсан, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон, үнийн өсөлтөд өртөмтгий, газар зүйн хувьд түгжигдмэл зэрэг хэт өрөөсгөл, эмзэг бүтэц бүхий Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй байхад гол анхаарлаа хандуулна.
- 7.6 Эдийн засгийн аюулгүй байдалд аюул учруулахуйц гадаад, дотоод сөрөг хүчин зүйлүүдийг саармагжуулах, тэдгээрийн эсрэг дархлаа суулгах, өөрийгөө тэнцвэржүүлэх чадвартай, эмзэг бус, бие даасан эдийн засагтай болгох бодлогыг дэмжинэ.

НАЙМ. ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ, МОНГОЛЫН ИРЭЭДҮЙГ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭГЧ ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА

- 8.1 Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог олон төрөлтэй, хамралт өргөнтэй болгож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг цахим мэдээллийн тогтолцоогоор холбож, иргэд хувиас хийж буй төлбөрийн улмаас санхүүгийн хүндрэл, ядууралд орох эрсдэлгүйгээр эрүүл мэндийн үндсэн тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох бодлогыг дэмжинэ.
- 8.2 Цар тахлаас урьдчилан сэргийлэх, ард түмний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахын тулд дотооддоо шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлууур, урвалж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл вакцин үйлдвэрлэх бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.
- 8.3 Нийгмийн халамжийг хавтгайруулан олгох бус зорилгот бүлэгт хүргэх нэгдсэн, ил тод, шилэн тогтолцоог бүрдүүлэх, давхардах, орхигдох байдлыг арилгах бодлогыг дэмжин ажиллана.

᠑᠑᠑᠑ ᠐᠑
᠑᠐1᠙12᠐3᠑᠑

- 8.4 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн бүтцийг оновчтой болгох замаар, эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг бэхжүүлэн, иргэд эрүүл мэндийн үйлчилгээг оршин суугаа газрын харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан эрүүл мэндийн даатгалаараа бүх шатлалын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэхийг дэмжинэ.
- 8.5 Эрүүл иргэн эх орны баялаг учир иргэдэд бие болон сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах мэдлэг, дадал зуршлыг эзэмшүүлэх, бүх насныханд тохирсон биеийн тамир, спортыг хөгжүүлэх, эрүүл агаарт дасгал хөдөлгөөн хийх, эрүүл мэндээ нөхөн сэргээх задгай талбай болон байгууламжийг дүүрэг, хороо бүрд байгуулах бодлогыг дэмжиж ажиллана.

ЕС. ИРГЭДЭЭ ТҮШСЭН, АЛЬ НЭГ БҮЛГИЙН БИШ НИЙТ МОНГОЛЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БАЙНА.

- 9.1 Монгол Улсын төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд иргэд, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай байнгын, шууд холбоотой байхыг эрхэмлэж, үндэсний, нийтийн эрх ашиг, Монгол хүний төлөө аливаа санал, санаачилгыг дэмжин ажиллана.
- 9.2 Төр, хувийн хэвшил, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог тэгш хангах, харилцан ойлголцох, нийтлэг эрх ашиг, үнэт зүйл, үндэсний хөгжлийн зорилгын төлөө хамтран ажиллах орчинг бүрдүүлэх зорилгоор орон тооны бус бодлогын зөвлөүүдийг байгуулан ажиллана. Дараах зөвлөүүдийг эн тэргүүнд санаачлан байгуулна. Үүнд:
- 1) **Үндэсний эв нэгдлийн бодлогын зөвлөл.** Монгол Улсын хөгжлийн алсын хараа, үндэсний соёл, үнэт зүйлс, нийтлэг эрх ашиг дээрээ тулгуурлан үндэсний эв нэгдлийг хангах, үндэсний эв нэгдлийн төлөө хүчин чармайлт гаргах аливаа төсөл, хөтөлбөр, санаа санаачилга, манлайллыг дэмжиж, эрдэмтэн, мэргэжилтнүүд, нийгмийн бүлэг, улс төрийн намуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.
 - 2) **Гадаадад суугаа монголчуудаа дэмжих бодлогын зөвлөл.** Гадаадад суугаа иргэд бол Монгол Улсын хөгжлийн том нөөц, дэлхийн хөгжилтэй холбох гүүр. Гадаадад суугаа иргэдээ хөгжлийн нэгэн тулгуур болгох бодлогыг цоо шинэ төвшинд гаргахыг дэмжиж, гадаад болон эх орондоо суугаа иргэд, нийгмийн төлөөллүүдийн оролцоог хангаж ажиллана.
 - 3) **Цахим хөгжил, технологийн бодлогын зөвлөл.** Мэдээллийн технологи хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлж, технологийн боловсрол, хэрэглээг төр, хувийн хэвшлийн бүх төвшинд нэвтрүүлэх аливаа ажил, санаачилгыг дэмжиж, залууст түүчээлэх боломж олгохыг онцгойлон анхаарч, нийгмийн төлөөллүүдийн оролцоог хангаж ажиллана.
 - 4) **Монгол брэндийг дэлхийд гаргах бодлогын зөвлөл.** Үндэсний брэндүүдийг дэмжих, шинээр Монгол брэндүүд хөгжүүлэн бий болгож дэлхийн зах зээлд гаргаж байршуулахад төр, бизнес, олон нийтийн байгууллагуудын хүч нөөц, төлөвлөгөөг нэгтгэн уялдуулж, бодлогын шийдэл гаргаж, хэрэгжүүлэхийг тууштай дэмжиж ажиллана.
 - 5) **Үндэсний баялгийн шударга хуваарилалтын бодлогын зөвлөл.** Баялгийн тэгш, шударга хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор баялгийн сан, эрүүл мэнд, нийгмийн даатгал, тэтгэврийн шинэчлэл, нийгмийн халамжийн оновчтой шударга тогтолцоог бүрдүүлэх шинэчлэлийн бодлогыг дэмжиж, мэргэжилтнүүд, төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудын оролцоог хангаж, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.